



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/664

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хоймор нутгийн ирээдүйн хүчтэн өсвөр, залуучуудын цомын аварга шалгаруулах нээлтэй тэмцээн зохион байгуулах арга хэмжээнд 1.800.000 (Нэг сая найман зуун мянга), Рэнчинлхүмбэ сумын уугуул Ч.Оюунгэрэл нь МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн цол тэмдгээр шагнагдсанд хүндэтгэл үзүүлж 500.000 (Таван зуун мянга) төгрөг, Мөрөн сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн сурагч Э.Хонгорзул нь Индонез улсад болох хийн буудлагын Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 500.000 (Таван зуун мянга) төгрөг, Улаанбаатар хотод болох Тусгай олимпын үндэсний спортын наадамд оролцох баг тамирчдын замын зардалд 729.600 (Долоон зуун хорин есөн мянга зургаан зуу) төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 3.529.600 (Гурван сая таван зуун хорин есөн мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

